

СТАНДАРТ НӨХЦӨЛ**Нэг. Агуулга**

- 1.1. “Вюрт Монголиа” ХХК /цаашид “Вюрт Монголиа” гэх/ нь өөрийн Худалдаа, үйлчилгээний стандарт нөхцөл /цаашид “стандарт нөхцөл” гэх/-ийг энэхүү баримт бичиг тусгасан бөгөөд энэ нь Худалдах, худалдан авах гэрээний ерөнхий нөхцөлийн хамт хүчинтэй болно.
- 1.2. Талуудын хооронд байгуулсан Худалдах, худалдан авах гэрээ нь энэхүү Стандарт нөхцөлийн зохицуулалтаас давамгайл байдлаар үйлчилнэ.

Хоёр. Гэрээ байгуулах

- 2.1. Худалдан авагч нь Вюрт Монголиагаас бараа нийлүүлэх нөхцөлтэй урьдчилан сайтар танилцсаны үндсэн дээр худалдаа, үйлчилгээг зохих ёсоор үзүүлэхэд шаардлагатай захиалгыг ойлгомжтой, тодорхой өгнө.
- 2.2. Вюрт Монголиа нь Худалдан авагч, түүний томилсон ажилтны бичгээр өгсөн захиалга, түүний нэмэлт өөрчлөлтийг Худалдан авагчийн баталгаат захиалга гэж үзнэ. Вюрт Монголиа захиалгыг хүлээн авч эргэн мэдэгдсэнээр захиалга баталгаажсанд тооцно.

Гурав. Барааны мэдээлэл

- 3.1. Вюрт Монголиагаас санал болгосон танилцуулгад дурдсан барааг Худалдан авагч захиалах боломжтой.
- 3.2. Хэрэв бараанд технологийн өөрчлөлт оруулсан тохиолдолд Худалдагч нь Худалдан авагчийн ашиглалтын зорилгод нийцсэн, үйлдвэрлэгчийн хамгийн сүүлийн үеийн загварын барааг нийлүүлж болно.
- 3.3. Үйлдвэрлэгчээс гаргасан чанарын үзүүлэлтийг Вюрт Монголиа болон Худалдан авагчийн тохиролцсон барааны чанар гэж тооцно.
- 3.4. Танилцуулга, үзүүлэн, холбогдох бусад сурталчилгааны материалд бичигдсэн барааны талаар мэдээллийн хувьд Вюрт Монголиа аливаа баталгаа гаргахгүй.

Дөрөв. Барааны үнэ

- 4.1. Захиалгын баталгаажуулалт дээр бичигдсэн барааны үнийг хүчинтэйд тооцно.
- 4.2. Зайлшгүй шалтгааны улмаас захиалсан барааны үнэ өөрчлөгдсөн тохиолдолд Худалдан авагчид урьдчилан мэдэгдэнэ.
- 4.3. Хэрэв тохиролцсон бараа хүргэлтийн хугацаа Худалдах, худалдан авах гэрээ байгуулагдсан өдрөөс хойш хоёр сараар удаашрах тохиолдолд Вюрт Монголиа нь бараа хүргэх үеийн үнийг баримталж болно. 10,000 төгрөг-100,000 төгрөгийн үнэтэй бараа нийлүүлэх жижиг захиалгын үед нийлүүлэлтийн ажиллагааны зардал ихэссэн эсэхийг харгалзан үзэж үнийг тогтооно.
- 4.4. Барааны үнэ нь “DDP (Delivered Duty Paid)-Улаанбаатар” нөхцөлийг агуулсан гэж үзнэ.
- 4.5. Үнийн дүнд НӨАТ багтаагүй бөгөөд үүнийг тогтоосон хувь хэмжээний дагуу тусад нь нэхэмжилнэ.
- 4.6. Худалдан авагч нь барааг заасан газраасаа өөр газарт хүргүүлэх тохиолдолд үүссэн нэмэлт зардлыг хариуцан төлнө.

Тав. Төлбөрийн нөхцөл

- 5.1. Худалдан авагч нь төлбөрийг Вюрт Монголиагаас хүргүүлсэн барааны төлбөрийн нэхэмжлэхэд заасан хугацаанд бүрэн хэмжээнд төлөх үүрэгтэй.
- 5.2. Барааны төлбөрийг нэхэмжлэх хүлээн авсан өдрөөс хойш 15 хоногийн дотор төлөөгүй тохиолдолд Худалдах, худалдан авах гэрээнд заасан (алданги, торгууль, хохирол төлөх) хариуцлага хүлээнэ.
- 5.3. Вюрт Монголиа нь Худалдан авагчийн төлсөн төлбөрөөс өмнөх барааны үлдэгдэл төлбөрийг тэргүүн ээлжинд суутгах эрхтэй. Хэрэв Худалдан авагч нь хохирол, алданги, торгууль төлөх нөхцөл байдал үүссэн тохиолдолд эдгээр дүнг Худалдан авагчийн төлсөн төлбөрөөс тэргүүн ээлжинд суутган төлүүлэх эрхтэй.

СТАНДАРТ НӨХЦӨЛ

5.4. Шаардлагатай тохиолдолд Вюрт Монголиа нь төлбөр бүрэн төлөгдсөний дараа барааг нийлүүлж болно.

Зургаа. Хүргэлт

6.1. Вюрт Монголиа нь Худалдан авагчийн захиалгын дагуу барааг "DDP (Delivered Duty Paid)-Улаанбаатар" нөхцөлөөр түүний заасан газарт хүргэж өгнө.

6.2. Вюрт Монголиагаас барааг хүргэх үед бараа нь хэмжээсийн хувьд хэвийн түвшинд хэлбэлзэлтэй байж болно.

6.3. Вюрт Монголиа нь зайлшгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд барааг хэсэгчлэн хүргэх эрхтэй. Захиалгат барааны тээвэрлэлтийн асуудлыг Вюрт Монголиагийн гэрээт тээвэрлэлтийн компани хариуцна.

6.4. Талууд барааг хүлээлцэхдээ акт үйлдэнэ. Актыг бараа хүлээлгэн өгсөн, хүлээн авсан ажилтан гарын үсэг зурж баталгаажуулна. Ийнхүү актыг үйлдсэнээр Вюрт Монголиа барааг хүлээлгэн өгсөн, Худалдан авагч барааг хүлээн авсанд тооцно.

6.5. Худалдан авагч нь барааг шалгаж авах үүрэгтэй. Барааны доголдлыг шалгуулах зардлыг Худалдан авагч хариуцна.

6.6. Худалдан авагч нь худалдан авсан, хэрэглээгүй, ямар нэг доголдолгүй барааг хүлээн авсан өдрөөс хойш зөвхөн хуанлийн 60 хоногийн дотор өөрийн савлагаа, боодолтой нь Вюрт Монголиад буцаан өгөх боломжтой. Энэ тохиолдолд Вюрт Монголиа нь 50,000 төгрөгөөс дээш үнийн дүнтэй барааны үнээс 20 хувийг суутган авч үлдэгдэл төлбөрийг буцаан олгоно.

6.7. Худалдан авагч нь энэхүү Стандарт нөхцөлийн 2.1 болон 6.5 дугаар зүйлүүдэд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд барааг хүлээн авахаас татгалзах эрхгүй.

6.8. Барааг хүлээн авахаас татгалзсан мэдэгдэл өгч барааг буцаах тохиолдолд Стандарт нөхцөлийн 6.6-д заасан журмыг баримтална.

Долоо. Эрсдэл шилжих нөхцөл

7.1. Актаар хүлээлгэн өгөх хүртэл хугацаанд үүссэн барааны эрсдэлийг Вюрт Монголиа, түүнээс хойших хугацаанд Худалдан авагч хариуцна.

7.2. Барааны тээвэрлэлтэй холбоотой аливаа эрсдэлийг тээвэрлэлтийн компани хариуцна.

7.3. Үйлдвэрлэгч нь нийлүүлсэн барааг зах зээлээс буцаан татах тохиолдолд Худалдан авагч нь өөрийн зардлаар Вюрт Монголиад хүргэнэ.

Найм. Барааны өмчлөлийн эрх болон зохиогчийн эрх

8.1. Вюрт Монголиа нь төлбөр бүрэн төлөгдөх хүртэл хугацаанд нийлүүлсэн барааны өмчлөгч хэвээр байна.

8.2. Вюрт Монголиад төлбөрийг бүрэн төлснөөр барааны өмчлөх эрх Худалдан авагчид шилжинэ.

8.3. Худалдан авагч нь барааг Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадагш экспортлохгүй.

8.4. Худалдан авагч нь бараатай холбоотой зохиогчийн эрх, барааны тэмдэг эзэмшигчийн эрх, холбогдох бусад оюуны өмчийн эрхийг эдлэхгүй.

Ес. Баталгаа

9.1. Барааны баталгаат хугацаа нь хүлээлгэн өгсөн өдрөөс хойш 12 сар байна.

9.2. Вюрт Монголиа баталгаат хугацааны дотор, ердийн ашиглалтын явцад бараанд илэрсэн үйлдвэрийн гэмтлийг засварлана. Ийнхүү засварлахдаа Вюрт Монголиа дараах хувилбарын аль нэгийг өөрийн үзэмжээр сонгож шийдвэрлэнэ. Үүнд:

9.2.1. Доголдолтой барааг солих, Хэрэв бараа нь үйлдвэрлэгдэхгүй, нийлүүлэгдэхгүй болсон тохиолдолд ойролцоо чанар, үзүүлэлт бүхий бараагаар солих.

9.2.2. Барааны үнийг буцаан олгох,

9.2.3. Хүлээн авсан өдрөөс хойш ажлын 20 өдрийн дотор засах.

9.3. Худалдан авагч болон түүний ажилтны хайхрамжгүй үйл ажиллагаа, ашиглалтын зааварчилгааг зөрчсөн, буруу хэрэглэсэн, хийц загварыг өөрчилсөн, зөвшөөрөлгүй засах гэж

Хуудас 2/4

Үйлчлүүлэгч

Монгол Өмгөөлөгч

.....

.....

СТАНДАРТ НӨХЦӨЛ

оролдсоны улмаас үүссэн аливаа шууд болон шууд бус эвдрэл, гэмтэлд баталгаа үйлчлэхгүй.

9.4. Худалдагчаас жишээ болгон үзүүлсэн барааны хувьд баталгаа гаргахгүй.

Арав. Гэрээг цуцлах

10.1. Аль нэг тал гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй эсхүл гэрээг ноцтой зөрчсөн, хууль тогтоомжид заасан тохиолдолд нөгөө тал гэрээг цуцалж болно.

10.2. Гэрээг цуцлах тохиолдолд Вюрт Монголиагийн нийлүүлсэн барааны төлбөрийг Худалдан авагч бүрэн төлнө.

10.3. Вюрт Монголиа нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас гэрээг үргэлжлүүлэх боломжгүй болсон тохиолдолд энэ талаар нөгөө талдаа 14 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

Арван нэг. Хариуцлагын хязгаарлалт

11.1. Стандарт нөхцөл болон Худалдах, худалдан авах гэрээний нөхцөл нь хамтдаа талуудын хоорондын харилцааг зохицуулах баримт бичиг байна. Вюрт Монголиа нь энэхүү стандарт нөхцөл болон Худалдах, худалдан авах гэрээний ерөнхий нөхцөлд тусгаагүй аливаа асуудлаар үүрэг хүлээхгүй.

11.2. Худалдан авагч болон түүний ажилтны буруутай үйл ажиллагаа, хайхрамжгүй байдал, Вюрт Монголиагаас өгсөн заварчилгааг баримтлаагүйн улмаас үүссэн аливаа хохирлыг Вюрт Монголиа хариуцахгүй.

11.3. Вюрт Монголиа нь өөрөөс хамааралгүй шалтгаан болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас барааг Худалдах, худалдан авах гэрээнд заасан хугацаанд нийлүүлж чадаагүй тохиолдолд, шалтгаан нөхцөлийн талаар Худалдан авагчид тайлбар өгөх бөгөөд хариуцлага хүлээхгүй.

11.4. Вюрт Монголиагийн илтэд буруутай үйл ажиллагаа эсвэл хүргэлт саатсаны улмаас бараанд үүссэн доголдлын хувьд Вюрт Монголиа захиалга тутамд 500,000 төгрөг хүртэл хэмжээний хариуцлага хүлээнэ. Вюрт

Монголиагаас нийлүүлээгүй Вюрт нэрийн барааны хувьд Вюрт Монголиа хариуцлага хүлээхгүй.

Арван хоёр. Нөхөн төлбөр

12.1. Худалдан авагч нь стандарт нөхцөл болон Худалдах, худалдан авах гэрээний ерөнхий нөхцөлд заасан үүргээ биелүүлээгүйн улмаас Вюрт Монголиад учруулсан хохирлыг нөхөн төлнө.

Арван гурав. Нууцлал

13.1. "Нууц мэдээлэл" гэдэгт Вюрт Монголиагийн нууц гэж тодорхойлсон бүх мэдээлэл хамаарна.

13.2. Нууц мэдээлэлд: (i) мэдээллийг олж авсан тал аль хэдийнээ мэдсэн, (ii) мэдээлэл хүлээн авагчийн буруугүй үйлдлээр олон нийтэд ил болсон, (iii) мэдээллийг хүлээн авагч тал өөрөө боловсруулсан бөгөөд (iv) хүлээн авагч тал гуравдагч этгээдээс ирүүлсэн мэдээлэл зэрэг нь хамаарахгүй.

13.3. Талууд "Нууц мэдээлэл" -ийг хадгалах үүрэгтэй бөгөөд эрх бүхий байгууллага, этгээдээс бусад этгээдэд задруулахгүй байхыг хүлээн зөвшөөрнө.

13.4. Худалдан авагч нь нэр, логогоо Вюрт Монголиагийн сурталчилгаанд ашиглуулахаа зөвшөөрч байна.

13.5. Вюрт Монголиагаас өгсөн бичгэн зөвшөөрөлгүйгээр барааны брэнд нэр, зураглал, дүрслэл холбогдох бусад мэдээллийг ашиглахыг хориглоно.

Арван дөрөв. Давагдашгүй хүчин зүйл

14.1. Аль нэг талаас үл хамаарах хүчин зүйл буюу галын аюул, бусад гэнэтийн осол, тохиолдол, байгалийн гамшиг, ажил хаялт, хөдөлмөрийн хамтын маргаан, дайн, бусад хүч хэрэглэсэн үйл явц, төр, түүний эрх бүхий байгууллагаас баталсан хууль, журам, тогтоол зэрэг нөхцөл, талуудаас хамаарахгүй шалтгаанаар барааны тээвэрлэлт саатах зэрэг шалтгааны улмаас гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэх

Хуудас 3/4

Үйлчлүүлэгч

Монгол Өмгөөлөгч

.....

.....

СТАНДАРТ НӨХЦӨЛ

боломжгүй болсон тохиолдолд аль нэг тал хариуцлага хүлээхгүй.

Арван тав. Тусгаар байдал

15.1 Энэхүү стандарт нөхцөлийн зүйл, заалт бүр бие даасан, тусгаар нөхцөлийг илэрхийлнэ. Аль нэг зүйл, заалт хүчин төгөлдөр бус болох нь гэрээний бусад заалтын хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй.

Арван зургаа. Татгалзал ба эрх шилжүүлэх

16.1. Аль нэг тал гэрээний дагуу эрхээ эдлэхгүй байх нь гэрээнээс татгалзах үндэслэл болохгүй.

16.2. Худалдан авагч нь гэрээний эрх, үүргийг нөгөө талын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр аливаа гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй.

Арван долоо. Хэрэглэгдэх хууль ба маргааны харьяалал

17.1. Худалдах, худалдан авах гэрээний ерөнхий нөхцөл болон энэхүү Стандарт нөхцөлийг Монгол улсын хууль тогтоомжийн дагуу тайлбарлах бөгөөд талууд аливаа маргааныг Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

Арван найм. Бүрэн цогц гэрээ

18.1. Энэхүү стандарт нөхцөл болон Худалдах, худалдан авах гэрээний ерөнхий нөхцөл нь хамтдаа талуудын хоорондын бүх тохиролцоог илэрхийлнэ.

18.2. Худалдах, худалдан авах гэрээний ерөнхий нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд талууд гарын үсэг зурж баталгаажуулна.

Арван ес. Хэл

19.1. Энэхүү стандарт нөхцөл нь Монгол, Англи хэл дээр бичигдсэн болно. Хэрэв утга агуулгын хувьд алдаатай, зөрүүтэй ойлголт гарвал Англи хувилбарыг баримтална.